



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ  
ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРОО

**Төрийн албан хаагчдыг  
үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлсөн  
асуудлаар зохион байгуулах нээлттэй  
сонсгол**

Улаанбаатар хот  
2014 оны 04 сарын 29


**Өргөдлийн байнгын хороонд 2014-2015 онд ажлаас чөлөөлөгдсөн асуудлаар нийт 179 иргэнтэй холбоотой өргөдөл ирсэн. Үүнээс:**

№	Өргөдөлд хамрагдах яам, газар	Иргэний тоо
1.	Хөдөлмөрийн яам, салбарын хэмжээнд	64
2.	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, салбарын хэмжээнд	66
3.	Эрүүл мэнд, спортын яам	11
4.	Хүнс, хөдөө аж ахуйн яам, салбарын хэмжээнд	14
5.	Барилга, хот байгуулалтын яамны салбар	5
6.	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны салбар байгууллага	8


# Зарим өргөдлүүдийн агуулга

- Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, Эрүүл мэнд, спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг **түр орлон гүйцэтгэгч нар** үндэслэлгүйгээр албан хаагчдыг чөлөөлөх шийдвэр гаргаж байна
- Тухайн албан тушаалтны чиг үүрэг хэвээр байхад албан тушаалын нэр, газар, хэлтсийн нэрийн бага зэрэг өөрчлөн бүтцийн өөрчлөлт нэрээр чөлөөлж байна
- Чөлөөлөгдсөн зарим албан хаагчид эхнээсээ шүүхэд гомдол гарган шүүхээс үндэслэлгүйгээр халагдсан гэсэн шийдвэр гарч эхэлж байна.

# Төрийн албан хаагчдын тоо 2012-2014 он



# Төрийн албан хаагчдын тоо 2015 оны 1 сарын 1-ний байдлаар – 183601



# Төрийн албан хаагчдын талаарх зарим статистик тоо, баримт

- Засгийн газрын бүтцэд 2014 онд нийт **3 удаа** өөрчлөлт, хөдөлгөөн орсон гэж Төрийн албаны зөвлөлийн 2014 оны тайланд орсон байна.
- Нийт төрийн байгууллагуудын хэмжээнд **1500-2000** орчим төрийн албан хаагч ажлаас чөлөөлөгдсөн мэдээ байна
- Сангийн яамны мэдээгээр Монгол Улсын 2015 оны тодотгосон төсөвт бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлөгдсөн албан хаагчдад нэг удаагийн тэтгэмж олгох зардалд нийт **5 тэрбум 378 сая 313 мянган төгрөг** тусгасан .

# Шүүхийн ерөнхий зөвлөлийн мэдээлэл

Он	Захиргааны хэргийн шүүх				Иргэний хэргийн шүүх	
	Ажилд эргүүлэн томилох төрийн албан хаагчийн нэхэмжлэл	Шүүхээр ажилд нь эргүүлэн томилохоор шийдвэрлэсэн	Ажилгүй байсан хугацааны цалин авахаар нэхэмжилж шийдвэрлэсэн тоо	Төрийн байгууллагаас гаргуулахаар шийдвэрлэсэн мөнгөн дүн	ТҮ-ний албан хаагчийг үндэслэлгүйгээр халсан хэргийг шийдвэрлэсэн тоо	Төрийн байгууллагаас гаргуулахаар шийдвэрлэсэн мөнгөн дүн
2013	159	82	68	365.950.127	372	549.194.755
2014	188	104	87	373.260.324	258	766.614.628
Нийт	347	186	155	<b>739.210.451</b>	630	<b>1.315.809.383</b>

2 жилд – **2 тэрбум 055 сая 019 мянга 834 төгрөг**

# Төрийн албаны зөвлөлийн 2014 оны тайлангаас

“Төрийн албаны зөвлөлийн тайланд **20 шахам хууль, эрх зүйн** актаар **110** гаруй ажлын байрны **350** шахам албан хаагчийг томилох, чөлөөлөх эрхийг Засгийн газрын гишүүдэд олгосон нь төрийн алба улс төрөөс ангид байх, ил тод, тэгш байх зарчмуудыг зөрчиж байна”



# Зарим өргөдлийн агуулга

**Усны тухай хуулийн** 10.1.11-д Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага “сав газрын захиргааны даргыг томилох, чөлөөлөх гэж” заасан байна

**-Д.Оюунхорол сайдын** 2015 оны 2 сарын 27-ны тушаалаар нэг зэрэг 17 сав газрын захиргааны дарга нарыг нэг дор чөлөөлж үүрэг гүйцэтгэгч нарыг томилж байна гэсэн өргөдлийг Байнгын хороонд ирүүлсэн.

# Зарим өргөдлийн агуулга

- **Хөдөлмөр эрхлэлтийн тухай хуулийн 29.3.-д** “Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын даргыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн томилж, чөлөөлнө” гэсэн.

**-С.Чинзориг сайдын** тушаалаар 2015 оны 3 сарын 24-оор тасалбар болгон 21 аймаг, 9 дүүргийн 30 хөдөлмөрийн хэлтсийн дарга, 27 Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн захирлуудыг чөлөөлсөн тухай өргөдөл Улсын Их Хуралд ирүүлсэн